



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 23 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 23 дугаар хуралдааныг 2025 оны 11 дугаар сарын 18-ны зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 23 дугаар хуралдаанаар /2025-11-18/ “ХХЗХ-ны үйл ажиллагааны дунд хугацааны стратеги: 2026-2030 он” баримт бичгийн төслийн тухай; ХХЗХ-ны 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн танилцуулга (хүлээгдэж буй гүйцэтгэлээр); Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Мобиком Корпораци ХХК-ийн хүсэлтийн тухай) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 6 (Тогтоол №239-244, 2025-11-18) тогтоолыг тус тус баталсан ба тус хорооны хуралдааны 2 тэмдэглэлээр ажлын албанд удирдамж үүрэг чиглэл болгохоор тогтов.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 23 дугаар хуралдаанд Хорооны даргын 2025 оны А/62 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс /Ажлын хэсгийн дарга, АА-ны дарга А.Лувсан-Очир/ боловсруулан Даргын зөвлөлийн 2025 оны 3 удаагийн хурлаар хэлэлцүүлсэн “Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны дунд хугацааны хугацааны стратеги: 2026-2030 он” баримт бичиг батлах тухай танилцуулга, стратегийн баримт бичгийн төсөл, тогтоолын болон хуралдааны тэмдэглэлийн төслийн тухай асуудлыг хэлэлцүүлэв. Энэхүү хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үеэр хорооны дарга, нэр бүхий гишүүдээс гарсан санал зөвлөмжийг тусгаж, тус Хорооны дүрмийн 2.1.2 дахь заалтыг үндэслэн “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026-2030 оны стратеги” батлах тухай 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 239 тоот тогтоолыг хавсралтын хамт батлав. Тогтоолд, “Энэхүү баримт бичгээр батлагдсан Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги болон байгууллагын жилийн төлөвлөгөө (Үйл ажиллагааны болон санхүүгийн)-ний уялдааг хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ. Хорооны хуралдааны тогтоолоор “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026-2030 оны стратеги” баримт бичгийг баталснаар Хорооны алсын хараа (*Дижитал эдийн засгийг дэмжих уян хатан, хамтын зохицуулалттай 5 дахь үеийн зохицуулах байгууллага байна*); эрхэм зорилго (*Бид харилцаа холбооны чанартай, дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хэрэглэгчийг хүртээмжтэй хангах, харилцан үр ашигтай хамтран ажиллах, ил тод, уян хатан зохицуулалтын тогтолцоог төгөлдөршүүлнэ.*) болон байгууллагын 5 стратегийн зорилгыг хэрэгжүүлэх 39 зорилтыг хүрэх үр дүнгийн хамт тус тус тодорхойлсон нь дунд хугацаанд баримтлан хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтыг шинэ шатанд гаргах чухал ач холбогдолтой баримт бичиг, хорооны шийдвэр болж байна.

Тус хуралдаанаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026-2030 оны стратеги батлах” тухай 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 239 тоот тогтоол батлагдсантай холбогдуулан Хорооны хуралдааны 023/02 дугаар тэмдэглэлээр цаашид дараах удирдамж, чиглэлийг хэрэгжүүлэн ажиллахыг Ажлын алба /А.Лувсан-Очир/-нд үүрэг болгохоор тогтов. Үүнд: Нэг. 1.“Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026-2030 оны стратеги”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан Хорооны даргын тушаалаар батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; 2. Батлагдсан баримт бичиг болон төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил, жилийн эцсээр Хорооны хуралдаанд хэлэлцүүлэн тайлагнаж ажиллахыг Ажлын албаны дарга болон бүтцийн нэгжийн дарга нарт үүрэг болгох зэрэг болно.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 20 дугаар хуралдааны үеэр Хорооны нэр бүхий гишүүдээс гаргасан санал, өгсөн даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор ЗУХАГ-ын Санхүүгийн хэлтсээс “ХХЗХ-ны 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн танилцуулга (хүлээгдэж буй гүйцэтгэлээр)”-ыг Хорооны 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит 23 дугаар хуралдаанаар сонсов.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 23 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 5 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 5 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 240 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 2 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрлийг (Парсек ХХК, Сетком ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 241 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Саран дэгрээ ХХК: “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” 12100655 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 242 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Төгс барчин хангай ХХК: Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх” 12900345 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Монвсат нэтворк ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 243 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1

тусгай зөвшөөрлийг (Монвсат нэтворк ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх” 12910012, 12910023 тоот тусгай зөвшөөрлүүдийг) хүчингүй болгосон;

- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 244 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдэд (Голомт банк ХК: 1800-1646; Гадаадын иргэн, харьяатын газар: 1800-1882) 2 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилээр сунгаж тус тус шийдвэрлэв.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 23 дугаар хуралдаанд тусгай зөвшөөрлийн тухай асуудлын хүрээнд ажлын албанаас Мобиком Корпораци ХХК-иас ирүүлсэн 2 хүсэлтийн талаар ажлын албаны болон хууль эрхзүйн дүгнэлт, хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзах тухай албан мэдэгдлийн төслийг тус тус танилцуулав. Энэхүү асуудлаар Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 9, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.2, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны 139 дүгээр тогтоолыг үндэслэн хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзах тухай Ажлын албаны дүгнэлтийг дэмжиж, албан мэдэгдлийг Хорооны даргын гарын үсэгтэй албажуулан хүргүүлэхээр тогтов.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг [энд дарж](#) үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-11-25